

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Банзрагчийн Хажид	Дугаар	L062
Оршин суугаа аймаг	Дорнод аймаг халх гол сум	Оршин суугаа сум	Халхгол сум
Төрсөн газар	Халхгол сум	Төрсөн он	1916
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Тамсагийн хийд	Сүм хийдийн дугаар	ДОХГ 042
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 13	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Халхгол сумын Тамсагийн хийд

-Бид Халх гол сумд байсан хүрээ хийдийн тухай судалж сурвалжилж явна. Та өөрийн санаж байгаа, сонссон дуулсан зүйлээ бидэнд хэлж өгнө үү?

Нас өндөр болсон болохоор ухаан санаанд юм орохоо байчихаж байгаа юм даа.

-Зүгээр дээ. Та өөрийн санаж байгаа зүйлээ л ярь даа. Таныг багад танайх хаагуур нутагладаг байсан бэ?

Манайх яг Буйрын урд биеэр. Өвөл бол баруунтаа Тамсагаар нутаглаж байлаа. Сүүлийн үед голоор нутаглаж байсан даа.

-Буйрын тэр хавьд мөн Тамсагийн тэр хавьд ямар ямар хүрээ хийд байсан бэ? Тэр тухай яриач?

Тамсагт яахав дээ. Сүүл үед л энэ Халхын сүмн лам нар Тамсагт ирсэн. Тамсаг булагийн эхэнд байсан. Манай жинхэнэ Халх голын хийд. Баруунтшаа манайхан чинь бүгдээрээ нүүгээд ирсэн.Тэгээд Зуухтын хийдэд очсон. Аймгаас баруун урагш. Тэнд байж байгаад цаашаа гарсан даа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Яагаад нүүсэн юм бэ? Үймээн самуун болсон юм уу?

Япон хамаг юмыг нь сандаагаад ирэхээр л нүүсэн. Нүүгээд Тамсагт ирсэн. Тэндээсээ тайван байхад л нүүгээд Матад сумын зүүн хойнох Зуухтад байсан.Халх голынхон чинь хачин. Шажин хурахад нүүсэн. Аймгаас баруун тийш. Хөлөнбуйрын байгаа тэр газар. Ер нь тэгж нүүж явсан. Үймээн самуун дайн байлдаан ч нөлөөлсөн.

-Матадын зүүн хойно хүртэл нүүхдээ хэдэн онд нүүсэн юм бэ?

-1939 онд л юм байна.

Буйрын хойно ямар хийд байсан бэ? Хойноо Халхын сүм?

Буйрын хойно хийд гэж байхгүй штээ. Халхын сүм гэж гэж хойшоо байсан. Одоо тэр Шарилжийн наахна байсан. Өнөө нэг том хүрээ л байгаа байх даа.

-Буйрын баруун талд, Улаан худгаас хойшоо ямар хийд байсан бэ?

Тэнд хийд гэж байгаагүй. Миний мэдэхийн. Тэнд застав л байсан.Хийд гэвэл урагшаа Өвөр хоолойд нэг хийд байсан. Баян Бүрдэнд. Манайхны Халхын сүм л их барилгатай байсан. Урдахууд нь дуган нь гэр л байсан. Том том гонхолчихсон гэрүүд л байсан.

Өвөр хоолой эндээс 60-аад км-т уу?

Тийм байх аа.

-Вангийн нуруу, Буйр хоёрын хооронд хийд, хурлын газар байсан уу?

Байхгүй байх аа.

-Хэрээ уулын энд Повронгийн тохой гэж байна уу? Тэнд То вангийн өвлийн ордон гэж байна уу?

Тэрийг би мэдэхгүй. Хүн асууж байсан бас. Хэрээ уулын зүүн сугад гэсэн байх. Энэ тал чинь зүүн сүм байсан.

Тэгээд сайн мэдэхгүй. Энэ чинь 4 сүм байсан. Халх гол сүм, Зүүн сүм, Баруун сүм, Хунт сүм гэж байсан.

-Тамсагийн тэр хавьд хэдэн газар байсан юм бэ? Хойшлоод Утай таван уул?

Тэнд хийд байсан.

Тамсагаас урагшаа Жамсран овоо гэж бий юу?

Тамсагаас баруун урагшаа тэнд байдаг. Эргэн тойрон учиргүй их манхантай. Дунд нь жаахан барилга шиг юмтай. Тэндээ дэлгээтэй жижиг Жамсран бурхан байдаг байсан. Эмэгтэй хүн гарч болохгүй л гэдэг байсан. Би багадаа нэг гарч л байсан. Жамсран овоог тахидаг байсан. Намар тахина. Хунтын лам нар л тахина. Сүүлд манай өвгөнийг нэг тахиад өгөөч гэсэн. Үгүй ээ би чадахгүй. Тэр чинь хүн бүр тахидаггүй. Хунтын лам нар л тахиж ёстой гэж хэлж байсан. Тэгсэн манайхны нэг хүн очиж тахисан. Тахиж ирээд 10-аад хоноод бие барсан. Манай өвгөн хэлж л байсан. Хүн бүр тахидаггүй овоо гэж.

-Хөгшний овоо буюу Өвгөн овоо гэж сумын төвөөс аль чигтэй вэ?

Одоо энэ урагшаа штээ. Баянбүрднээс урагшаа. Өвгөн овоо гэж бий. Ёнгорын овоо гэж бий. Дэргэдээ нууртай. Дээр нь шувуутай. Бид тэр шувууг цохих гэж оролддог байсан.

-Өвгөн овооны тэнд ямар хийд байсан бэ? Эрхэмсэг бэйс гэж хийд байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэрүүхэн хойд дээр нь Панжигнайлан гэж хийд байсан. Хунтын (сүм) сүм. Тухай тухайдаа(цаг цагийн хуралтай байсан) л хурна. Нутгийн хурлын дэглэм чинь дандаа тухай тухайдаа л хурдаг байсан юм.

Өвгөн овоо Сангийн далайда хамаарах уу?

Өө, Сангийн далай, Туулайт, Гүн нуур гээд бүр баруунтшаа.

-Сангийн далайн ард нэг хийд байсан гэдэг юм байна лээ?

Аа, тийм үү? Мэдэхгүй. Сангийн далайд чинь хэчнээн тэрэг давс орж Сангийн далай болсон юм гэнэ лээ. Тэрийг ёстой дуулаачгүй. Захын Да вангийн хошуу байсан. Их л заргач хүн байсан гэж. Хаанаас ч ирсэн, ямар ч хүн байсан заргаа алдана гэж байдаггүй авдаг тийм хүн байсан юм гэнэ лээ.

-Халхын сүмын тухай?

Жинхэнэ манай Халх голын сүм. Халхын сүм их том хийд байсан. Их л бурхан сахиустай байсан. Хурал хурж байхыг нь би мэднэ. Манай ах нар Халхын сүмд байсан.

Та энэ тухайгаа тодруулаач? Ямар ямар хүн сууж байсан бэ?

Манай Амбаа бол хамгийн том хурал хуруулсан лам байсан. Хэн хүний хуруулдаагүй хурлыг хуруулж байсан гэдэг. Алтан малгай өмсчихсөн цавьдар морьтой ирж байсан. Ямар хурал гэдгийг мэдэхгүй байна. Манай өвгөн Балдан гэж унзад нь байсан.

Халхын сүмд Чойр дацан гэж байсан уу?

Байсан байлгүй дээ.

-Халхын сүмийн төвд нэр нь юу гэдэг байсан бэ?

Тэрийг мэдэхгүй.

-Халхын сүм хэзээ байгуулагдсан бэ?

Их л эрт байх даа. Намайг жаахан байхад би чинь 92-той (2007) их сайхан сүм байсан. Чухам хэдийд байгуулсны мэдэхгүй.

-Хэдэн дугантай байсан бэ?

Гол сүм гэж байсан. 3 дугантай байсан. Эргэн тойрон хүрдтэй. Гадуураа тойроод хэрэмтэй. Гол сүмд нь алтан ембүү суулгасан гэж ярьдаг байсан байх аа. Булсан л гэж ярьдаг. Зүүн талаар нь л байдаг байх. Надаас тэрнийг л амьтан асуудаг юм.

-2 тусдаа хэрэмтэй тус тусдаа дуганууд байсан уу?

Тийм.

-Зүүн талынх нь арай том, баруун талынх нь арай жижиг? Гол сүм нь зүүн талынх нь хэрэмтэйд байсан уу?

Аа тийм байлгүй дээ. Том нь л байх ёстой доо.

-Тэрнээс гадна хэрмийн гадуур байсан тууриуд юу вэ? Сүм дуган байсан уу юм уу?

Гадуур нь бунхан шиг юмтай хүрднүүд л байсан даа. Урд талд нь 2 хүрд. Баруун зүүн талд нь 2 хүрд. Том оо, Том. Эхэн боть гэж их сайхан сайхан юм байсан даа.

-Эхэн боть гэж ямар учиртай юм бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Номнууд. Их том том ном. Хүн үүрээд лай ланчигаа гаргаж байдаг байсан.

-Ганжуур, Данжуур Улаан юм гэсэн судрууд уу?

Тийм ээ. Тэрний боть шүү дээ. Гадуураа модон хавтастай. Дунд нь сайхан баринтагаар ороочихсон.

-Халхын сүмээс үлдсэн ном судар бурхан тахил гэж байна уу?

Ер нь үгүй байх аа. Тэр үед чинь өөрснийхөө гэрийн бурхан тахилыг ч нууж хааж байлаа штээ.